



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

121 /121/

2021.08.26

## ҮЙЛ ЯВДАЛ

### “ЦЭРГИЙН ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ” ШИНЭЧЛЭГДНЭ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн захиралжаар “Цэргийн цол олгох журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдлаа. Ажлын хэсгийн даргаар Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, орлогч даргаар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо бүрэлдэхүүнд нь Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Батлан хамгаалах яам, Хууль зүй дотоод хэргийн яам болон Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах албан тушаалтнууд томилогдон ажиллаж байна.

Цэргийн цол нь цэргийн албан хаагчийн эрхэлж байгаа албан тушаалын ангиллын илэрхийлэл, түүнийг цэргийн боловсрол, цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанд харгалзуулсан зэрэг дэв мөн.

Сүүлийн үед цэрэг, цагдаагийн байгууллагуудад цэргийн цолны зохистой харьцаа алдагдаж, түүний дотор ахлах офицеруудын эзлэх хувь нийт офицеруудын тоонд харьцуулахад өндөр, тэрчлэн офицерын цолны зэрэг дэвийн шаардлагыг хангаагүй, цэргийн зохих ёсны боловсрол эзэмшээгүй, цэргийн алба хаагаагүй, офицерын албанд элсүүлэх насны дээд хязгаар хэтэрсэн иргэд, спорт урлагийнханд цэргийн цолыг хавтгайруулан олгож байгаа зэрэгт ард иргэд, олон нийт шүүмжлэлтэй хандаж, мэрэгжлийн армийн ноён нуруу болсон офицерын бүрэлдэхүүний алба хаах хүсэл зориг, итгэл үнэмшлийг бууруулж байгаа юм.

Иймд тус ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн баталдаг



одоогийн мөрдөж байгаа “Цэргийн цол олгох журам”, Дайчилгааны болон цэрэг-стратегийн сургалтад оролцсон цэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн цол олгодог хууль эрх зүйн зохицуулалтанд өөрчлөлт оруулж дээрх гажуудлыг засахаар ажиллаж байна.

Түүнээс гадна өнөөгийн мөрдөж байгаа “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-д Монгол Улсын Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, дотоодын цэрэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Тагнуулын байгууллагад алба

хааж байгаа офицер, ахлагч, цэргийн сургуулийн сонсогч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан загварын цэргийн дүрэмт хувцсыг өмсөж, цол, ялгах тэмдгийг дүрэмд заасны дагуу хэрэглэнэ” гэж тодорхой заасан байтал цэргийн дүрэмт хувцсыг хэн дуртай нь зөвшөөрөлгүй өмсөх, үйлдвэрлэх, худалдаалах зэрэг зөрчлүүд элбэгшиж цэргийн дүрэмт хувцасны нэр хүндийг бууруулж байна.

Ажлын хэсэг цэргийн дүрэмт хувцасны хууль бус хэрэглээний талаар “Цэргийн дүрэмт хувцсыг өмсөх дүрэм”-д заасан хууль, эрх зүйн заалтуудын хэрэгжилтийг хэрхэн хангах талаар санал дүгнэлтээ бас боловсруулна.

Ингэснээр цэргийн албаны нэр хүнд өсч, цэргийн алба хаагчдын албаа хаах итгэл үнэмшил дээшилнэ гэж ажлын хэсэг үзэж байна.

**Эх сурвалж:**  
**Ерөнхийлөгчийн Тамгын газрын хэвлэл мэдээллийн алба**

## МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагч, хилийн чанадад үүргээ нэр төртэй гүйцэтгэж буй энхийг сахиулагч, эх орноо батлан хамгаалах үйлсэд хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэнд Монгол Улсад Залуучуудын байгууллага үүсэж, хөгжсөний түүхт 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

1921 оны 8 дугаар сарын 25-ны энэ өдөр Монголын залуучуудын анхны байгууллага болох “Бошгыг халах залуучуудын эвлэл”-ийг байгуулж, улмаар Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл болон хөгжиж үйл

ажиллагаагаа явуулж байсан түүхтэй бөгөөд энэхүү өдрийг манай улсад залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний ойн баярын өдөр хэмээн жил бүр тэмдэглэсээр ирсэн юм.

Манай орны хөгжлийн түүхэнд цоо шинэ эргэлтийг авчирсан 1921 оны Ардын хувьсгалын ялалтыг улам бүр баталгаажуулан улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа бататган хамгаалах, ард олныг бичиг үсэгт сургах, эрүүлийг хамгаалах, орчин үеийн соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан, анагаах ухааны ололтыг нэвтрүүлэх, аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх, их бүтээн байгуулалтад оролцох зэрэг бүтээлч үйл ажиллагаанд залуучуудын маань оруулсан

хувь нэмэр асар их билээ.

Монгол Улсын түүхэнд өнгөрсөн зуун жилийн хугацаанд Монгол ардын журамт цэргээс эхтэй орчин цагийн Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нь хуулиар хүлээсэн чиг үүргүүдийг амжилттай гүйцэтгэж, эх орноо харийн түрэмгийллээс чөлөөлөх, энх цагийн бүтээн байгуулалт, хөгжил дэвшилд манлайлах үүрэгтэй оролцох, даян дэлхийд амар амгаланг тогтоох энхийн үйлсэд идэвхийлэн зүтгэсээр байна. Энэхүү бүтээлч үйлс, бахдам түүхийг бүтээхэд тухайн үеийн Ардын Армийн ХЗЭ-ийн байгууллага, ахмад ажилтнууд, гишүүд, дэмжигчид ихээхэн үүрэг,

оролцоотой байсныг баярын энэ өдөр онцлон тэмдэглэж байна.

Зэвсэгт хүчнийхээ өнөөгийн түүхийг баяжуулж яваа залуучууд Та бүхэн ахмад үеийнхний хөдөлмөрч, баатарлаг, дайчин уламжлал, ажлын дадлага, туршлагыг нь улам бүр дэлгэрүүлж, үйл ажиллагаандаа цаг ямагт хэрэгжүүлнэ гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлэхийн сацуу дахин баярын мэндийг дэвшүүлж, ажил үйлсэд тань арвин их амжилт, аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн ерөөе.

Монгол цэргийн сүр хүч, суу алдар мандан бадрах болтугай!

### АРДЫН АРМИЙН ХЗЭ-ИЙН АХМАД АЖИЛТНУУДЫН “ДАЙЧИН НӨХӨД” ХОЛБОО

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 200.274 +2433	ЭДГЭРСЭН 184.119 +1479	НАС БАРСАН 913 +6
-----------------------------------	---------------------------	----------------------

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4500 +80	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 175 +28	ЭДГЭРСЭН 4238 +14
-----------------------------	--------------------------------	----------------------

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

**Тохиолдол**  
Нийт: 214,695,774

**Эдгэрсэн**  
Нийт: 192,024,264

**Нас барсан**  
Нийт: 4,475,352

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 13	🌧️ 3

### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 25

## ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.849.0	2.852.0
EUR 🇪🇺	3.351.0	3.360.0
CNY 🇨🇳	440.0	441.0
RUB 🇷🇺	37.80	39.00
JPY 🇯🇵	25.73	26.17
KRW 🇰🇷	2.39	2.48

## ЗУРХАЙ

2021.08.26 ПҮРЭВ ГАРАГ  
/БИЛГИЙН ТООЛЛЫН 19/

### НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ УЛААН МОРЬ ӨДӨР

**Үс засуулбал:**  
**Сайн нөхөртэй нөхөрлөнө**  
**Наран ургах, шингэх:**  
**06.02-19.46**  
**Барилдлага:**  
**Үл зохилдох**  
**Шүтэн барилдлага:**  
**Төрөн түгэхүй**  
**Суудал:**  
**Мод**

Тухайн өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба лусыг тахиж, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн.

Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нөхөртэй учрах” хэмээх сайн.

**МОГОЙД**  
ХАЗУУСАН ҮЕД АВАХ АНХНЫ ТУСЛАМЖ

**ХОРГҮЙ МОГОЙ:**  
• ХОЛДОЛ ОУГАА ХААГАХ  
• ТЭВЭГ ТЭВЭГЭЙГ ӨГӨӨН ХААХ  
• ХӨДӨЛМӨРЧ, АЖЛЫН ДАДЛАГА, ТУРШЛАГЫГ НЬ УЛАМ БҮР ДЭЛГЭРҮҮЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ЦАГ ЯМАГТ ХЭРЭГЖҮҮЛНЭ ГЭДЭГТ ИТГЭЛ ТӨГС БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЭХИЙН САЦУУ ДАХИН БАЯРЫН МЭНДИЙГ ДЭВШҮҮЛЖ, АЖИЛ ҮЙЛСЭД ТАНЫ АРВИН ИХ АМЖИЛТ, АЗ ЖАРГАЛ, ЭРҮҮЛ ЭНХ, САЙН САЙХАН БҮХНИЙГ БЭЛГЭДЭН ЕРӨӨЕ.

**ХОРТЙ МОГОЙ:**  
• ИВЭЛЭГ ДАХИ  
• ХААХ ЭТӨӨ ГАРГАВАЛ  
• ХӨДӨЛМӨРЧ, АЖЛЫН ДАДЛАГА, ТУРШЛАГЫГ НЬ УЛАМ БҮР ДЭЛГЭРҮҮЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ЦАГ ЯМАГТ ХЭРЭГЖҮҮЛНЭ ГЭДЭГТ ИТГЭЛ ТӨГС БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЭХИЙН САЦУУ ДАХИН БАЯРЫН МЭНДИЙГ ДЭВШҮҮЛЖ, АЖИЛ ҮЙЛСЭД ТАНЫ АРВИН ИХ АМЖИЛТ, АЗ ЖАРГАЛ, ЭРҮҮЛ ЭНХ, САЙН САЙХАН БҮХНИЙГ БЭЛГЭДЭН ЕРӨӨЕ.

## "СЭЛЭНГЭ-2021" ХЭЭРИЙН СУРГУУЛИЙН III ШАТНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУРАЛ БОЛЛОО



Монгол, Оросын хамтарсан "Сэлэнгэ-2021" байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн III шатны төлөвлөлтийн хурал ОХУ-ын Улаан-Үүд хотод 2021 оны 8 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Уг арга

хэмжээнд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, ОХУ-ын Зэвсэгт хүчний Дорнод цэргийн тойргийн 36 дугаар армийн штабын дарга И.Б. Тимофеев болон бусад албаны хүмүүс оролцов.

Тус сургууль 2021 оны 9 дүгээр сарын 20-ноос 10 дугаар сарын 5-ны өдрүүдэд Монгол Улсын Зэвсэгт хүчний дугаар ангийн сургуулийн төвд зохион байгуулагдах юм.

Ахмад Ц.ГАНБАТ

## ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ТОГООЧИЙН МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИНЭ



Монгол Улсын Засгийн газраас 2021 онд гаргасан ажилгүйдэлтэй тэмцэх, залуучуудыг ажил мэргэжилтэй болгох төслийн хүрээнд Зэвсэгт хүчний Жанжин штаб, "Монголын ресторан зоогийн газрын холбоо"-той хамтран Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, анги, байгууллагуудын хугацаат цэргийн алба хаагчидтай 10 хоногийн тогоочийн сургалтыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн

байрлалд зохион байгуулав. Сургалтад Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлээс гадна Зэвсэгт хүчний 014, 015, 120, 326 дугаар ангиудын хугацаат цэргийн алба хаагчид өөрсдийн хүсэлтээр суралцаж байна. Тус сургалтыг Монголын ресторан зоогийн газрын холбооны дэд захирал С.Батбаатар удирдан зохион байгуулж байгаа бол "Гүн шим" рестораны захирал Ш.Эрдэнэхүү, ШУТИС-ийн технологич

багш Н.Долгорсүрэн нар онол, "Модерн номадс" рестораны ерөнхий тогооч Л.Алтаншагай, Б.Бархассүрэн, Хүнний үйлдвэрийн дарга Г.Соёлмаа нар дадлагын хичээлүүдийг зааж байгаа юм. Сургалт 2021 оны 8 дугаар сарын 26-нд дуусаж цэрэг дайчид тогоочийн мэргэжлийн үнэмлэхээ гардан авахаас гадна өөрсдийн хийсэн гарын хоолоор үзэсгэлэнг зохион байгуулна.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

## ЦАГ АГААРЫН МЭДЭЭ



Өнөөдөр нутгийн зүүн хагаст үүлэрхэг, бусад нутгаар солигдмол үүлтэй. Баруун, төв, говийн аймгуудын нутгийн зарим газар, зүүн аймгуудын ихэнх нутгаар бороо орно. Салхи ихэнх нутгаар баруун хойноос секундэд 5-10, Алтайн салбар уулсаар секундэд 12-14 метр хүрч ширүүснэ. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, Хүрэнбэлчир орчим, Завхан голын эх, Идэр, Тэс, Эг, Үүр, Тэрэлж голын хөндийгөөр 8-13, говийн бүс

нутгийн өмнөд хэсгээр 19-24 бусад нутгаар 13-18 хэм дулаан байна. УЛААНБААТАР ХОТ ОРЧМООР: Үүлэрхэг. Бороо орохгүй. Салхи хойноос секундэд 5-10 метр. 13-15 хэм дулаан байна. БАГАНАУУР ОРЧМООР: Үүлэрхэг. Бага зэргийн бороо орно. Салхи хойноос секундэд 5-10 метр. 13-15 хэм дулаан байна. ТЭРЭЛЖ ОРЧМООР: Үүлэрхэг. Бага зэргийн

бороо орно. Салхи хойноос секундэд 5-10 метр. 11-13 хэм дулаан байна. Өглөө 05 цагт Улаанбаатарт: 9 хэм дулаан, харьцангуй чийг 79 хувь, агаарын даралт 871 гектопаскаль байлаа. Даралт өдөртөө тогтвортой байна. Өнөөдөр нутгийн зүүн хэсгээр бороо үргэлжлэн орж, ихэнх нутгаар сэрүүхэн байна.

Эх сурвалж: ЦУОШГ

## ЦЭРГИЙН АЖИГЛАГЧ ОФИЦЕР, СЕКТОР КОМАНДЛАГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2021-2022 онд үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч офицер, сектор командлагчийн сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд зохион байгуулна.

С о н г о н шалгаруулалтад оролцох хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд шинээр батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

ЖУРАМ" –тай танилцаж, НҮБ-ын цэргийн ажиглагч, штабын ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ. Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Ажил байдлын тодорхойлолт;

3. Жолооны үнэмлэхийн хуулбар;
  4. Цэргийн ажиглагч, штабын офицерын сургалт, дамжаа дүүргэсэн сертификатын хуулбар;
  5. Сүүлийн 3 сарын дотор авхуулсан 4x6 хэмжээтэй цээж зураг 2 хувь;
  6. Төвч судалгаа;
  7. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт.
- Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 92115982, 92096622/-тэй холбогдож тодруулж болно.

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын төв штабт дараах ажлын байранд үүрэг гүйцэтгэх (Р-3, Р-4, Р-5) сонирхолтой офицеруудын сонгон шалгаруулалтыг 2021 оны 9 дүгээр сарын 1-3-ны өдрүүдэд зохион байгуулна.

Үүнд: Сургалтын офицер Р-4 Дүн шинжилгээний офицер Р-3 Сургалтын офицер Р-3 Дүн шинжилгээний офицер Р-4 Энхийг сахиулах ажиллагаа хариуцсан офицер Р-4

Төлөвлөлтийн офицер Р-4 (Хүний нөөц, бодлого төлөвлөлт) Холбогч офицер Р-4 Цэргийн зөвлөхийн туслах Р-5 Ахлах холбогч офицер Р-5 С о н г о н шалгаруулалтад хамрагдах хүсэлтэй цэргийн алба хаагчид 2021 онд шинээр батлагдсан "ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ" –ыг судлан танилцаж, НҮБ-ын штабын

ажилтанд тавигдах шаардлагыг хангасан байх ба ЗХЖШ-ын АУГ-ын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор харьяа командлал, газар, хэлтсээр дамжуулан саналаа ирүүлнэ. Холбогдох албан тушаалын жагсаалт, тавигдах шаардлага, дэлгэрэнгүй мэдээллийг psod@mil.gov.mn цахим мэйл хаягаар болон 3203, 92115982, 92096622 утсаар холбогдож тодруулж болно.

## 12-17 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН 59.4 ХУВЬ НЬ ВАКЦИНД ХАМРАГДЛАА

Нийслэлийн хэмжээнд өчигдрийн байдлаар

- I тунд 778,
- II тунд 2658,
- III тунд 3214,

нийт 6650 иргэнийг дархлаажууллаа.

Ва к ц и н ж у л а л т эхэлснээс хойш нийслэлийн нийт хүн амын I тунгийн хамралт 73.9, II тунгийн хамралт 68.7 хувьтай байна.



Зорилтот бүлгийн буюу 2611 (21.9 хувь) жирэмсэн эх, 12-15 насны 52821 (59.4 хувь), 16-17 насны 22446

(66.2 хувь) хүүхэд тус тус дархлаажуулалтын бүрэн тунд хамрагджээ.